

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3.Аудитын тайлан.....	10
3.1. Ерөнхий зүйл.....	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	10
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл.....	12
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.9. Аудитын илрүүлэлт.....	13
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	13
Аудитын зөвлөмж.....	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	14
4. Менежментийн захидал.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	17

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
Д.ЗАГДЖАВ ТАНАА

2021.02.25 № 07/496
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал, дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Төвлөрсөн хангалтын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Төвлөрсөн хангалтын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлаг, байгууллагуудын гадаад харилцаа хариуцсан алба хаагчдын 3 дугаар зөвлөгөөн зохион байгуулах арга хэмжээ Ковид-19 цар тахлын улмаас зохион байгуулагдаагүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

төгрөгөөр

	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,905,746,858.12	9,667,524,432.35
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	2,498,325,715.19	549,197,009.50
311	Кассад байгаа бэлэн мөнгө	10,253,995.00	-
31110	Төгрөг	10,253,995.00	-
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	2,488,071,720.19	549,197,009.50
31210	Төгрөг	2,488,071,720.19	549,197,009.50
31211	Төрийн сангийн харилцах	73,700,001.00	549,196,913.50
31213	Арилжааны банк дахь харилцах	2,414,371,719.19	96.00
33	АВЛАГА	639,029,122.85	4,656,929,075.83
33500	Бусад авлага	639,029,122.85	4,656,929,075.83
3351	Байгууллагаас авах авлага	238,306,125.85	4,431,985,078.83
3352	Хувь хүмүүсээс авах авлага	400,722,997.00	224,943,997.00
34	УРЬДЧИЛГАА	1,599,696,625.70	52,413,510.00
34600	Урьдчилж төлсөн зардал	1,599,696,625.70	52,413,510.00
35	БАРАА МАТЕРИАЛ	4,168,695,394.38	4,408,984,837.02
35100	Дуусаагүй үйлдвэрлэл	471,593,913.00	440,112,400.00
35200	Бэлэн бүтээгдэхүүн	2,370,839,122.02	2,460,718,598.57
35400	Хангамжийн материал	1,326,262,359.36	1,508,153,838.45
35410	Бичиг хэргийн материал	531,000.00	88,500.00
35420	Аж ахуйн материал	179,276,755.17	183,979,599.45
35440	Түлш, шатах тослох материал	179,870,386.00	87,669,761.00
35450	Барилгын засварын материал	75,718,216.32	61,335,370.00
35460	Хүнсний материал	169,424,389.52	239,897,820.00
35470	Бусад хангамжийн материал	721,441,612.35	935,182,788.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,905,746,858.12	9,667,524,432.35
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,118,613,402.95	130,129,973.41
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,118,613,402.95	130,129,973.41
41300	Өглөг	762,113,401.95	100,129,973.41
41360	Бусад өглөг	762,113,401.95	100,129,973.41
41361	Байгууллагад өгөх өглөг	512,113,401.95	100,129,973.41
41362	Хувь хүмүүст өгөх өглөг	250,000,000.00	-
41400	Урьдчилж орсон орлого	356,500,001.00	30,000,000.00
41430	Барьцаа, дэнчингийн урьдчилж орсон орлого	73,700,001.00	30,000,000.00
41440	Бусад урьдчилж орсон орлого	282,800,000.00	-
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ДҮН	7,787,133,455.17	9,537,394,458.94
51	Засгийн газрын хувь оролцоо	7,787,133,455.17	9,537,394,458.94
51200	Хуримтлагдсан үр дүн	7,787,133,455.17	9,537,394,458.94
51210	Өмнөх үеийн үр дүн	7,787,133,455.17	7,779,944,655.17
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,757,449,803.77
VIII	НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,905,746,858.12	9,667,524,432.35

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

төгрөгөөр

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	18,150,686,147.11	17,812,105,287.83
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	731,723,233.99	975,166,609.33
120	Нийтлэг татварын бус орлого	731,723,233.99	814,548,539.58
120002	Хүүгийн орлого	92,029,492.65	25,137,355.64
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	639,693,741.34	789,411,183.94
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	585,442,957.70	481,899,049.99
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	54,250,783.64	307,512,133.95
122	Тусламжийн орлого	-	160,618,069.75
122001	Хандив тусламж /дотоод	-	160,618,069.75
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	17,418,962,913.12	16,836,938,678.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	11,960,103,942.00	12,154,196,906.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	11,960,103,942.00	12,154,196,906.00
1330	Төсвийн захирагчдаас	5,458,858,971.12	4,682,741,772.50
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,057,106,571.12	2,402,193,972.50
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	2,401,752,400.00	2,280,547,800.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,498,493,927.00	11,361,353,494.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,498,493,927.00	11,361,353,494.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,954,973,637.22	5,192,969,490.70
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	-	25,914,548.00
210102	Нэмэгдэл	-	25,914,548.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	10,058,786.00
210301	Гэрэл, цахилгаан	-	171,600.00
210302	Түлш, халаалт	-	9,887,186.00
2104	Хангамж, бараа материалын зардал	677,544,886.81	472,900,070.28
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	430,000.00
210402	Тээвэр, шатахуун	-	3,600,000.00
210404	Ном, хэвлэл	-	11,680,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,367,649.40	48,274,462.32
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	624,632,638.48	405,933,687.26
210408	Бараа материал акталсны зардал	35,544,598.93	2,981,920.70
2105	Нормативт зардал	2,095,743,841.91	1,474,559,878.52
210502	Хоол, хүнс	17,986,518.00	1,014,750.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,077,757,323.91	1,473,545,128.52
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,866,000.00	23,560,002.20
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,856,000.00	220,002.20
210604	Урсгал засвар	5,010,000.00	23,340,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	676,008,631.05	402,525,740.70
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	569,480,220.01	244,343,145.00
210803	Даатгалын үйлчилгээ	103,831,952.04	108,121,795.70
210807	Газрын төлбөр	2,556,261.00	50,000,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	140,198.00	60,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,478,810,277.45	2,783,450,465.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,440,483,077.45	2,718,214,965.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	38,327,200.00	65,235,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,543,520,289.78	6,168,384,003.41
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,853,635,437.00	3,212,685,019.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	3,373,835,437.00	2,280,763,919.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	479,800,000.00	931,921,100.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	111,824,204.49	15,067,032.00

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	111,824,204.49	15,067,032.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,578,060,648.29	2,940,631,952.41
213501	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,578,060,648.29	2,940,631,952.41
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	5,652,192,220.11	6,450,751,793.72
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,076,897,376.18	4,693,301,989.95
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	268,815.52
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал	3,076,897,376.18	4,693,033,174.43
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	2,575,294,843.93	1,757,449,803.77

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	21,299,383,340.78	17,784,933,886.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,616,556,847.28	1,021,853,233.87
120	Нийтлэг татварын бус орлого	3,616,556,847.28	861,235,164.12
120002	Хүүгийн орлого	92,029,492.65	25,137,355.64
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,494,554,602.03	836,097,712.48
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,494,554,602.03	836,097,712.48
120009	Бусад орлого	2,029,972,752.60	96.00
122	Тусламжийн орлого	-	160,618,069.75
122001	Хандив тусламж /дотоод	-	160,618,069.75
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	17,682,826,493.50	16,763,080,652.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	11,960,103,942.00	12,154,196,906.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	11,960,103,942.00	12,154,196,906.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	262,894,900.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	262,894,900.00	-
1330	Төсвийн захирагчдаас	5,459,827,651.50	4,608,883,746.50
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,058,075,251.50	2,328,335,946.50
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	2,401,752,400.00	2,280,547,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	18,611,862,726.59	19,734,062,592.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	18,611,862,726.59	19,734,062,592.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14,383,508,185.10	16,583,019,907.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	-	33,684,694.41
210101	Үндсэн цалин	-	7,770,146.41
210102	Нэмэгдэл	-	25,914,548.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,132,256.29	-
210201	Тэтгэврийн даатгал	2,972,256.29	-
210205	Эрүүл мэндийн даатгал	160,000.00	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	10,058,786.00
210301	Гэрэл, цахилгаан	-	171,600.00
210302	Түлш, халаалт	-	9,887,186.00
2104	Хангамж, бараа материалын зардал	97,839,300.00	73,815,580.00
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	215,000.00
210402	Тээвэр, шатахуун	77,882,600.00	6,000,000.00
210404	Ном, хэвлэл	-	20,710,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,956,700.00	46,890,580.00
2105	Нормативт зардал	3,592,487,922.96	3,653,969,177.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	18,408,100.00
210502	Хоол, хүнс	869,327,288.80	869,325,642.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,723,160,634.16	2,766,235,435.00

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Төвлөрсөн хангалтын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,014,315,038.00	990,353,172.59
210601	Багаж, техник, хэрэгсэл	959,293,488.00	871,883,842.59
210604	Урсгал засвар	55,021,550.00	118,469,330.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,289,185,627.75	4,151,215,437.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,193,244,566.01	3,981,421,957.00
210803	Даатгалын үйлчилгээ	93,244,602.74	119,732,680.00
210807	Газрын төлбөр	2,556,261.00	50,000,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	140,198.00	60,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,386,548,040.10	7,669,923,060.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,346,220,840.10	7,590,219,010.06
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	40,327,200.00	79,704,050.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,228,354,541.49	3,151,042,685.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,853,635,437.00	3,135,975,653.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	3,373,835,437.00	2,335,855,553.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	479,800,000.00	800,120,100.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	111,824,204.49	15,067,032.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	13,349,065.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	111,824,204.49	1,717,967.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	262,894,900.00	-
213504	Хөрөнгийн	262,894,900.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,687,520,614.19	-1,949,128,705.69
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	262,894,900.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	262,894,900.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	262,894,900.00	-
220001	Барилга байгууламж	217,684,000.00	-
222001	Тоног төхөөрөмж	45,210,900.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-262,894,900.00	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2,424,625,714.19	-1,949,128,705.69
101	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	73,700,001.00	2,498,325,715.19
10	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	2,498,325,715.19	549,197,009.50

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

төгрөгөөр

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл			5,216,897,282.24	5,216,897,282.24
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-5,058,671.00	-5,058,671.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			5,211,838,611.24	5,211,838,611.24
Тайлангийн үеийн үр дүн			2,575,294,843.93	2,575,294,843.93
2019 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл			7,787,133,455.17	7,787,133,455.17
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-7,188,800.00	-7,188,800.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			7,779,944,655.17	7,779,944,655.17
Тайлангийн үеийн үр дүн			1,757,449,803.77	1,757,449,803.77
2020 оын 12 сарын 31-р үлдэгдэл			9,537,394,458.94	9,537,394,458.94

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,248,477,100.00	12,163,282,439.00	85,194,661.00	99.30
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	12,248,477,100.00	12,163,282,439.00	85,194,661.00	99.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,111,851,100.00	9,027,306,786.00	84,544,314.00	99.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	33,684,800.00	33,684,694.41	105.59	100.00
210101	Үндсэн цалин	7,770,200.00	7,770,146.41	53.59	100.00
210102	Нэмэгдэл цалин	25,914,600.00	25,914,548.00	52.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,058,800.00	10,058,786.00	14.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	171,600.00	171,600.00	-	100.00
210302	Түлш, халаалт	9,887,200.00	9,887,186.00	14.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	73,815,600.00	73,815,580.00	20.00	100.00
210401	Бичиг хэрэг	215,000.00	215,000.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	6,000,000.00	6,000,000.00	-	100.00
210404	Ном, хэвлэл	20,710,000.00	20,710,000.00	-	100.00
210406	БҮТЭЗҮЙЛС	46,890,600.00	46,890,580.00	20.00	100.00
2105	Нормативт зардал	3,656,502,500.00	3,653,969,177.00	2,533,323.00	99.93
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,408,100.00	18,408,100.00	-	100.00
210502	Хоол хүнс	872,347,200.00	869,325,642.00	3,021,558.00	99.65
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,765,747,200.00	2,766,235,435.00	-488,235.00	100.02
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	989,038,300.00	990,353,172.59	-1,314,872.59	100.13
210601	Багаж, техник хэрэгсэл	870,568,900.00	871,883,842.59	-1,314,942.59	100.15
210604	Урсгал засвар	118,469,400.00	118,469,330.00	70.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,190,233,700.00	4,107,454,636.00	82,779,064.00	98.02

210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,020,501,000.00	3,937,721,956.00	82,779,044.00	97.94
210803	Даатгалын үйлчилгээ	119,732,700.00	119,732,680.00	20.00	100.00
210807	Газрын төлбөр	50,000,000.00	50,000,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	158,517,400.00	157,970,740.00	546,660.00	99.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	77,936,700.00	78,266,690.00	-329,990.00	100.42
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	80,580,700.00	79,704,050.00	876,650.00	98.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,136,626,000.00	3,135,975,653.00	650,347.00	99.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,136,626,000.00	3,135,975,653.00	650,347.00	99.98
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,336,505,900.00	2,335,855,553.00	650,347.00	99.97
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,120,100.00	800,120,100.00	-	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,248,477,100.00	12,163,473,439.00	85,003,661.00	99.30
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	12,239,817,100.00	12,152,669,939.00	87,147,161.00	99.29
310001	Улсын төсвөөс санхүүжих	12,239,817,100.00	12,152,669,939.00	87,147,161.00	99.29
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	8,660,000.00	10,803,500.00	-2,143,500.00	124.75

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Төвлөрсөн хангалтын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Д.Загджав танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Үндэсний аудитын газрын ахлах аудитор Ж.Болормаа, аудитор Д.Мөнхжин нар хариуцаж хэрэгжүүлэв.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Төвлөрсөн хангалтын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06/19 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Төвлөрсөн хангалтын стратегийн зорилтыг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Стратегийн зорилт 1. Иргэний хэргийн талаарх шүүхийн шийдвэр, хуульд заасан тохиолдолд бусад байгууллагын шүүхээр баталгаажуулсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах.
- Стратегийн зорилт 2. Эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийдвэрийн биелэлтийг нэгтгэн зохион байгуулах.
- Стратегийн зорилт 3. Үйлдвэрлэлийг хөгжүүлэн үйл ажиллагааных нь үр дүнд хорих ял эдлэгсдийг ажлын байраар хангах.
- Стратегийн зорилт 4. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, удирдлагын манлайллыг хангах, хяналт-шинжилгээ хийх, үнэлж дүгнэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулан иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас өгсөн хандивын судалгаагаар ХЗДХЯ-аас 165.0 мянган төгрөгийн хандив авсан байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Төвлөрсөн хангалт нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хяналт шалгалтын газар 2020 онд ШШГЕГ-ын харьяа байгууллагын үйл ажиллагаанд 7 төлөвлөгөөт, 11 төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж хяналт шалгалтын хүрээнд анги, байгууллагуудаас илэрсэн нийт 49 төрлийн зөрчлийг газар дээр нь буюу шалгалтын явцад арилгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэн, 137 төрлийн зөрчлийг арилгуулах 1-2 сарын хугацаатай үүргийг анги, байгууллагуудад хүргүүлж, дүнг тооцсон байна. ШШГЕГ-ын даргын өгсөн үүргийн дагуу дэлхий дахинд тархсан Ковид-19 халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр өгсөн үүрэг,

зөвлөмжийг хэрхэн хангаж байгааг шалган зааварчилж, дүнг удирдлагад танилцуулж, анги, байгууллагуудад шалгалтын дүн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар албан бичгээр үүрэг хүргүүлж ажилласан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Төвлөрсөн хангалтын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлого 17,812,105.3 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 356,242.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад материаллаг байдлыг өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Төвлөрсөн хангалтын 2020 оны санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 761,777.6 мянган төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, урьдчилж төлсөн зардлын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	2,498,325.7	549,197.0	(1,949,128.7)
АВЛАГА	639,029.1	4,656,929.0	4,017,899.9
УРЬДЧИЛГАА	1,599,696.6	52,413.5	(1,547,283.1)
БАРАА МАТЕРИАЛ	4,168,695.3	4,408,984.8	240,289.5
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,905,746.8	9,667,524.4	761,777.6
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,118,613.4	130,129.9	(988,483.5)
Хуримтлагдсан үр дүн	7,787,133.4	9,537,394.4	1,750,261.0
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	8,905,746.8	9,667,524.4	761,777.6

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө дансны үлдэгдэл 1,949,128.7 мянган төгрөгөөр буурсан нь Төрийн банкны харилцах дансыг хааж төрийн санд шилжүүлсэн бөгөөд тайлант онд харьяа газруудын дээд байгууллагад төвлөрүүлэх орлогын дүн буурснаас шалтгаалжээ. Түүнчлэн, 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 338,580.8 мянган төгрөгөөр буурсан нь дээрхтэй холбоотой байна.

Авлага данс 4,017,899.9 мянган төгрөгөөр өссөн нь ажилчдын орон сууцны барилгын ажлын санхүүжилт 3,946,483.3 мянган төгрөгийг Төвлөрсөн хангалт дансны тайланд авлагаар шилжүүлж бүртгэсэнтэй холбоотой байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 1,547,283.1 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онд Агуу луу ХХК-д төлсөн барилгын ажлын санхүүжилтийн урьдчилгаа 1,447,094.0 мянган төгрөгийг хааж барилгын санхүүжилтийн авлагад бүртгэсэнтэй холбоотой байна.

Бараа материалын данс 4,408,984.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оноос материаллаг өөрчлөлтгүй байна. Үүнээс нормын хувцасны үлдэгдэл бараа материалын үлдэгдлийн 54 хувийг эзэлж байна.

Бусад хангамжийн материал дансанд бүртгэлтэй 360,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий LX 570 автомашиныг ТӨБЗГ-ын 2020 оны 453 дугаар тогтоолоор Засгийн газрын автобаазад шилжүүлсэн бөгөөд автомашин нь 2018 оноос хойш ашиглагдаж байсан боловч үндсэн хөрөнгөнд бүртгэлгүй, ашигласан хугацааны элэгдэл тооцоогүй байна.

Нийт зардал өмнөх оноос 1,137,140.4 мянган төгрөгөөр буурсан нь хангамж, бараа материалын зардал, нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж болон урсгал шилжүүлгийн зардал буурсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд тайлант оны үр дүн нэмэгдсэнээс бусад өөрчлөлт ороогүй байна.

Төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын Төсвийн төлөвлөгөө батлах тухай 2019 оны А/220 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар дээд байгууллагад төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг баталсан байна. Гүйцэтгэлээр харьяа нэгжүүдээс дээд байгууллагад төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг анх төлөвснөөс 550,000.0 мянган төгрөгөөр бууруулж 2,580,000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн нь өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад 1,448,989.4 мянган төгрөгөөр бага байна.

Хүснэгт 2 Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

2019 оны төлөвлөгөө, гүйцэтгэл		2020 оны төлөвлөгөө, гүйцэтгэл		Гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан зөрүү
Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
3,754,300.0	4,072,599.2	2,580,000.0	2,623,609.8	(1,448,989.4)

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийг 14,680,605.0 мянган төгрөгөөр, үүнээс бараа үйлчилгээний зардлын төсвийг 10,631,857.3 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 4,048,747.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс 12,248,477.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 70705, 70711 буюу 2 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 12,248,477.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 12,239,817.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 8,660.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 12,154,196.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны 10,803.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, нийт 12,163,282.4 мянган төгрөг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 1,718.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсөвт байгууллагын туслах үйл ажиллагааны орлогыг 8,660.0 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 10,803.5 мянган төгрөг бүрдүүлснээс 191.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд нийт 590 гүйлгээний мэдээлэл оруулахаас 557 гүйлгээний мэдээлэл оруулж 33 гүйлгээний мэдээллийг хугацаа хоцроож, 14,000.0 мянган төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 7,188.8 мянган төгрөгийн актыг бүрэн барагдуулж, 3,985.4 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 4 зөвлөмжийн хэрэгжилтийг аудитын явцад дахин хянахад хэрэгжилт 87.5 хувьтай байна. Үүнээс он дамжсан авлагын үлдэгдлээс 20,000.0 мянган төгрөгийг тайлант онд барагдуулсан байна.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 312,860.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 209,000.0 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 103,860.6 мянган төгрөгийн 3 зөвлөмж өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Залруулагдаагүй алдаа, зөрчилд дараах албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

1. Автомашин худалдах, худалдан авах тухай 2020/018 дугаартай гэрээний дагуу 195,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий автомашиныг худалдан авч Хорих ял эдлүүлэх албанд шилжүүлсэн боловч холбогдох хууль журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2-т “Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.” гэсэн заалттай нийцэхгүй, Үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Шилэн дансны тухай хуулийн дагуу цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ гарсан тухай бүр мэдээлэх үүрэгтэй боловч 7 дугаар сарын 33 гүйлгээг хугацаа хоцроож, 6 дугаар сарын 14,000.0 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;”-ээр долоо хоногийн дотор мэдээлнэ” гэж заасантай нийцэхгүй, Үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд авлага, өр төлбөрийн тооцоо нийлж баталгаажуулах, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц дараах асуудлууд байна. Үүнд:

1. Хорих ангиудаас төвлөрүүлсэн 3,946,483.3 мянган төгрөгийн орлогыг ажилчдын орон сууцны барилгын ажлын санхүүжилтэд зарцуулж, тайлант онд авлагаар шилжүүлэн бүртгэсэн нь Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан А/40 67 дугаар тушаалаар баталсан "Хорих ангийн болон хувийн өмчийн хуулийн этгээдийн хамтарсан үйлдвэрээс олсон орлогыг хуваарилах, түүнд хяналт тавих журам"-ын 3.4-д заасантай нийцэхгүй байна.

2. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2020 оны А/50 болон А/89 тушаалын дагуу төрийн буруутай үйл ажиллагааны улмаас 140 иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирол 2,410,229.8 мянган төгрөгийн нөхөн төлбөр олгосон байна. Төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ." 50.2-д "Төрийн албаны төв байгууллага шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар бүртгэл хөтөлж, төрд учруулсан хохирлын нөхөн төлөлтөд хяналт тавьж, нөхөн төлөгдөөгүй тохиолдолд төрийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана." гэж заасны дагуу Шийдвэр гүйцэтгэх албанаас Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн 2020 оны 4/102 дугаартай албан бичгийн биелэлтийг авч үзнэ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд үүссэн 6,000.0 мянган төгрөгийн авлага, 10,736.4 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, ЦЕГ-т шилжсэн албан хаагчийн 18 сарын тэтгэмжийн урьдчилгаа төлбөр 17,491.4 мянган төгрөг бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалттай нийцээгүй, Эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайланд авлага, өр төлбөр бодитоор бүртгэгдээгүй байх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Санхүүгийн тайланд авлага, өр төлбөр үүсгэхгүй байж авлага ба өр төлбөрийн тооцоог хянаж баталгаажуулах, шилжсэн албан хаагчийн тэтгэмжийн урьдчилгаа төлбөрийг шилжүүлэх.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төсвийн шууд захирагчид асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

2. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт

Тайлант онд эд хогшил, урсгал засварын зардал 1,314.8 мянган төгрөгөөр батлагдсан төсвөөс хэтэрсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах,” гэсэн заалттай нийцээгүй, Үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл

Төсвийн төслийг бодитой төсөвлөхгүй байх, төсвийн хууль хэрэгжихгүй байх.

2.3. Өгсөн зөвлөмж

Төсвийн төслийг үндэслэлтэй бодитой төсөвлөж, батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төсвийн шууд захирагчид асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

3. Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Бараа үйлчилгээний бусад зардал болон нэг удаагийн шагнал урамшууллын зардалд бүртгэсэн 68,318.0 мянган төгрөгийн зардлын нотлох анхан шатны баримтын бүрдэл дутуу байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалттай нийцээгүй, Үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээг зардалд бүртгэсэн байх.

3.3. Өгсөн зөвлөмж:

Баримтын бүрдэл хангасан анхан шатны баримтыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэлд тусгаж ажиллах.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төсвийн шууд захирагчид асуудлын бүртгэлээр танилцуулсан бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахаа мэдэгдсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо	Аудитын нэр	2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код
2021			САГ-2021/27/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Төвлөрсөн хангалт		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд үүссэн авлага, өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	34,227.8	Зөвлөмж өгөх	СААХ-ийн дарга	Д.Бямбадорж
2	Эд хогшил, урсгал засварын зардал 1,314.8 мянган төгрөгөөр батлагдсан төсвөөс хэтэрсэн байна.	1,314.8	Зөвлөмж өгөх	СААХ-ийн дарга	Д.Бямбадорж
3	Бараа үйлчилгээний бусад зардал болон нэг удаагийн шагнал урамшууллын зардалд бүртгэсэн 68,318.0 мянган төгрөгийн зардлын нотлох анхан шатны баримтын бүрдэл дутуу байна.	68,318.0	Зөвлөмж өгөх	СҮХОГ-ын дарга СААХ-ийн дарга	Н.Цэвэлмаа Д.Бямбадорж
4	Автомашин худалдах, худалдан авах тухай 2020/018 дугаартай гэрээний дагуу 195,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий автомашиныг худалдан авч Хорих ял эдлүүлэх албанд шилжүүлсэн боловч холбогдох хууль журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.	195,000.0	Албан шаардлага	Дарга СҮХОГ-ын дарга	Д.Загджав Н.Цэвэлмаа
5	Шилэн дансны тухай хуулийн дагуу цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ гарсан тухай бүр мэдээлэх үүрэгтэй боловч 7 дугаар сарын 33 гүйлгээг хугацаа хоцроож, 6 дугаар сарын 14,000.0 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй байна.	14,000.0	Албан шаардлага	СҮХОГ-ын дарга СААХ-ийн дарга	Н.Цэвэлмаа Д.Бямбадорж
ДҮН		312,860.6			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 34/А0170071

Улаанбаатар хот

СЭГ- 2021/27/СТХ-ТЦЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Төвлөрсөн хангалтын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Автомашин худалдах, худалдан авах тухай 2020/018 дугаартай гэрээний дагуу 195,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий автомашиныг худалдан авахдаа холбогдох хууль журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2-т "Энэ хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ.", 8 дугаар зүйлийн 8.4-т "Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Д.Загджав, Санхүү үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын газрын дарга Н.Цэвэлмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

С.Мөнхжин

Ц.НАРАНЧИМЭГ
Ж.БОЛОРМАА
Д.МӨНХЖИН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kherel\Alban_Shaardlaga\2021\0225auditin 2-R Газар11.Docx

001081053



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25 № 35/А070071
СМ 2021/27/СТА-ТЦЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Төвлөрсөн хангалтын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн дагуу цалингийн зардлаас бусад 5,000.0 мянган төгрөгөөр дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ гарсан тухай бүр мэдээлэх үүрэгтэй боловч 7-р сарын 33 гүйлгээг хугацаа хоцроож, 6-р сарын 14,000.0 мянган төгрөгийн 2 гүйлгээг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж мэдээллийг хугацаанд нь, үнэн зөв, ил тод байршуулж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга Д.Загджав, Санхүү үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын газрын дарга Н.Цэвэлмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

(Handwritten signature)

Ц.НАРАНЧИМЭГ
Ж.БОЛОРМАА
Д.МӨНХЖИН

